Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа* | *2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр* |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: “Хай Би Ойл” ХК<br>УБД: 9010001063<br>Үнэт цаасны код:<br>Утасны дугаар: 88119740, 99904034 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | “Монголын Хөрөнгийн Бирж” ХК |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Үйлдвэрлэлийн салбар, Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Эвидексе Аудит ХХК |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 52,118,954 ширхэг |

*Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр:*

Хай Би Ойл ХК менежер Л.Даваагэрэл,

ТУЗ нарийн бичгийн дарга Н.Батнайрамдал

1 *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Борлуулалт: 2023 оны жилийн эцэсээр 864,889,597.73 төгрөгийн борлуулалтын орлого, 149,367,745.75 төгрөгийн өртөгтэй.

Цэвэр ашиг нь: 51,040,035.42₮

Авлага: 234,126,198.0 төгрөг

Өглөг: 149,687,026.0 төгрөг байна.

Зардалууд:

1. Цалингийн зардалд 88,826,828.46₮
2. НДШ-д 28,512,990.05₮
3. Ашиглалт болон урсгал засвар үйлчилгээнд 31,146,317.98₮
4. Албан татварт 47,499,211.10₮
5. Түлш шатахуун тээвэрт 145,813,283.22₮
6. Элэгдэл, хорогдлын зардал 102,095,290.17₮
7. Шуудан холбоо,бичиг хэрэг, даатгалд 3,540,009.52₮
8. Засвар үйлчилгээнд 34,799,169.45₮
9. Түрээс 2,100,000₮
10. Харуул хамгаалалт 22,400,000₮
11. Бусад зардалд 127,716,809.94₮ -ийн зардлууд тус тус

гарсан байна.

Нийт зардал нь: 634,449,909.89₮

| | | |
|---|---|---|
| 1.1 | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд "Эвиденсе аудит" ХХК хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлт гаргахаар ажиллаж байна. |
| 1.2 | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт духьдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/*<br>Хуулийн хугацаандаа холбогдох захидал аудитын тайлангаа хүргүүлэн ажиллана. | |
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1 | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Санхүүгийн үзүүлэлт:<br>Ашигт ажиллагаа |
| 2.2 | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | |
| 2.3 | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | |
| 2.4 | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Санхүү байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, үйлчилгээ байхгүй болно. |
| 2.5 | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Тайлант хугацаанд банк болон банк санхүүгийн байгууллага болоод бусад хувь хүн хуулийн этгээдээс ямар нэгэн зээл аваагүй болно. |
| 3. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*<br>3.1. Их хэмжээний хэлцэл: Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.<br>3.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл: Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно. | |
| 4 | *Цалин урамшууллын мэдээлэл:*<br><br>2023 онд нийт 8 ажилчинтайгаар үйл ажиллагаа явуулж цалинд 200,192,722.67₮<br>1 ажилчинд орон сууцны буцалтгүй тусламжаар 81,600,600.0₮ зарцуулсан | |
| 5 | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*<br>2023.04.24 "Хай Би Ойл" ХК-ийн ХЭХ-ын хурлын талаар:<br>2023 оны 04 сарын 24-ны өдрийн Баасан гаригийн 11:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18235 товчооны зам гудамж, 59 тоотод байрлах өөрийн байранд зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.<br>a.Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах<br>b. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох<br>c. Компанийн ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл. | |

Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудсанд тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.

Удирдлагын талаархи мэдээлэл:

2023.04.24-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Пүрэвбаатар, Ш.Амар-Отгон, Т.Батгэрэл, С.Одгэрэл, Р.Оюунбат, Б.Дөлгөөнтамир нар, хараат бус гишүүдээр А.Харцага, Т.Тамир, Н.Гүнжидмаа нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Дөлгөөнтамир, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр Н.Батнайрамдал нар сонгогдож ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

ТУЗ-ийн хурлын талаар:

Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 7 удаа санал асуулгаар хуралдсан байна. Үүнд:

1. 2023 оны 02 сарын 06-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж “Эвиденсе аудит”ХХК-аар 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх шийдвэрийг гаргасан.
2. 2023 оны 02 сарын 06-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж “Хай Би Ойл” ХК-иыйн хувьцаа эзэмшигчдэд 2022 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хувиарлахгүй болохыг тогтоож шийдвэрлэсэн.
3. 2022 оны 03 сарын 15-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг 2023 оны 04 сарын 24-ны Даваа гаргигийн 11 цагт хуралдуулхаар шийдвэрлэсэн.
4. 2023 оны 05 сарын 02-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2023 оны 04 сарын 24-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар томилогдсон ТУЗ-ын гишүүдээс ТУЗ-ын дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж шийдвэрлэсэн болно. Мөн өдөр Хай Би Ойл ХК-ийн ахлах оператор П.Баатархүүд нэг удаагийн буцалтгүй тусламж олгож шийдвэрлэсэн.

6 *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*

7 *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*

Компани нь нийт 52’118’954 ширхэг хувьцаатай ба 386 хувьцаа эзэмшигчидтэй байна.
Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Нийт хувьцааны Тоо ширхэг | Хувь |
|---|---|---|---|
| 1 | “Төгөлдөр мегаминкс” ХХК | 8,256,727 15. | 84% |
| 2 | “Кибер цирк” ХХК | 16,609,841 | 31,87% |
| 3 | “Монгол алтан минт” ХХК | 4,167,934 | 8.00% |
| 4 | “Нью альфа” ХХК | 17’327’908 | 33.25% |
| | | Дүн | 88.95% |

/ ҮЦТХТ-өөс 2023.04.04-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /

8 *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл*

8.1. “Хай Би Ойл” ХК нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.

9 *Ногдол ашгийн мэдээлэл:* Хай Би Ойл ХК 2024 оны 02 сарын 05 өдрийн ТУЗ-ийн хурлын 03 тоот тогтоолоор 2023 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон.

10 *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл*

2023 онд тус компани нь”Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн буюу нийгмийн хариуцлагын чиглэлээр 4,5 сая төгрөгний үнэ бүхий нийт 11 нэр төрлийн мод тарьсан. /Хар мод, шинэс, гацуур, хус, тэсмэг, порита, хайлаас, агч, улиас, голт бор, монос/

| | |
|---|---|
| | *Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2024 оны 03 дугаар сарын 13* |

Овог, нэр: Ш.Амар-Отгон
Албан тушаал: “Хай Би Ойл” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ………………………………………

(Тамга/тэмдэг) (Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Батнайрамдал

Албан тушаал:ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ………………………………………